ХОТ ТӨЛӨВЛӨЛТ,
СУДАЛГААНЫ ИНСТИТУТ

УЛААНБААТАР ХОТОД ШИНЭЭР БАРИГДАХ ТУУЛЫН ХУРДНЫ ЗАМЫН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ

ГЕОДЕЗИ, ЗУРАГЛАЛЫН АЖЛЫН ТАЙЛАН

УЛААНБААТАР 2025

“ Тав Ди Ворлд” ХХК

ТУУЛЫН ХУРДНЫ АВТО ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛД ЗОРИУЛСАН ГЕОДЕЗИ, ЗУРАГЛАЛЫН АЖЛЫН ТАЙЛАН

Тайлан боловсруулсан: **“ТАВ ДИ ВОРЛД” ХХК**

Хянасан: **Л. Бат-Эрдэнэ / Захирал /**

Тайлан бичсэн: **Д. Батсүх / Геодезийн инженер /**

Г. Батмөнх / Геодезийн инженер /

Тайланг хүлээж авсан:

MONGOLIA
Baatar ERKHEMBAYAR
CONSULTING ENGINEER
95-36

2024 он

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1. **ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**
   - Ажил гүйцэтгэсэн талбайн ерөнхий байршлын бүдүүвч
   - Ажил гүйцэтгэсэн үндэслэл, гэрээ
   - Гүйцэтгэсэн ажлын хэмжээ
2. **БАГИЙН ГИШҮҮД БОЛОН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ**
   - Багийн гишүүд
   - Тоног төхөөрөмж
3. **ФИЗИК ГАЗАРЗҮЙ**
   - Газарзүйн онцлог
   - Уур амьсгал
   - Хот төлөвлөлт, зам харилцаа
4. **Талбайн хэмжилтийн ажил**
   - Хуучин цэгийн судалгаа
   - Статик хэмжилтийн ажил
   - Нивелирдлэгийн III ангийн хэмжилтийн ажил
   - Зураглалын хэмжилтийн ажил
   - Нислэг төлөвлөлт
   - Агаарын зураглал
   - Агаарын шугамын унжилтын хэмжилт
5. **СУУРИН БОЛОВСРУУЛАЛТ**
   - Зургийн солбицол өндөр гаргаж авах
   - Агаарын зургийн бодолт
   - Байр зүйн тоон зураг зурах
6. **ЗАХИАЛАГЧИД ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН МАТЕРИАЛ**
   - Байр зүйн зураг файлаар .dwg
   - Ортофото зураг файлаар .tiff, .jpeg
   - Зураглалын ажлын тайлан хэвлэмэлээр 2 хувь
7. **ХАВСРАЛТУУД**
   - №1 Ажил гүйцэтгэсэн талбайн байршлын ерөнхий схем
   - №2 Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл
   - №3 Багаж тоног төхөөрөмжүүдийн баталгаажилтын гэрчилгээ
   - №4 Байрлалын сүлжээний хэмжилтийн бодолтын тайлан
   - №5 Өндрийн сүлжээний хэмжилтийн схем
   - №6 Өндрийн сүлжээний хэмжилтийн журнал
   - №7 Агаарын зургийн паспорт
   - №8 Цэг тэмдэгтийн хувийн хэрэг

Товчилсон нэр томьёоны тайлбар

WGS-84	World Geodetic System 1984	Дэлхийн Геодезийн Систем 1984
WGS-84 reference ellipsoid	World Geodetic System 1984 reference ellipsoid	Дэлхийн Геодезийн Систем 1984
UTM	Universal Transverse Mercator	Олон Нийтийн / Бүх Дэлхийн Хөндлөн Меркаторийн Солбицлын Систем
UAV	Unmanned Area Vehicle	Нисгэгчгүй нисэх төхөөрөмж
DTM	Digital Terrian Model	Газрын гадаргууг дүрсэлсэн тоон загвар
DEM	Digital Elevation Model	Газрын гадаргуугийн өндрийн тоон загвар
GPS	Global Positioning System	Дэлхийн байрлалын систем
GCP	Ground Control Point	Газрын хяналтын цэг
GNSS	Global Navigation Satellite System	Дэлхийн навигацийн хиймэл дагуулын систем
GSD	Ground sample distance	Агаарын зургийн зэрэгцээ хоёр пикселийн төв хоорондох зайны газар дээрх зайг илэрхийлэх утга
PPK	Post Processed Kinematic	Бодит цаг хугацаанд биш боловсруулалтын дараах үр дүн
RTK	Real Time Kinematic	Бодит агшинд байршил тодорхойлох технологи
TIFF	Tagged Image File Format	Тоон дүрс зургийн шахаагүй файлын формат

RGB	Red Green Blue	Улаан ногоон хөх өнгийн хослолоор бодит өнгийг илэрхийлэх загвар
PDOP	Position Dilution Of Precision	MNS 3951:20. Хиймэл дагуулын геометр байрлалаас байршил ба цагийг тодорхойлох нарийвчлалыг бууруулах үзүүлэлтийг тодорхойлох хүчин зүйл
JPEG	Joint Photographic Experts Group	Тоон дүрс зургийн шахсан файлын формат
ITRF	International Terrestrial Reference Frame	Олон Улсын Газрын тооллын тулгуур тогтолцоо

Зарим нэр томьёо, тодорхойлолт

Агаарын зураглал: Байр зүйн болон дэвсгэр зураг зохиох ба шинэчлэх, газрын гадаргуугийн талаарх орон зайн бусад өгөгдөл цуглуулах зорилгоор агаарын зураглалын нэг эсвэл өөр төрлийн эсвэл нэгэн зэрэг хоёр ба түүнээс олон зураглалын системээр агаарын хөлгөөс болон нисгэгчгүй нисэх төхөөрөмжөөр газрын гадаргууг зураглах үйл ажиллагаа.

Агаарын зураглалын материал: Шаардлага хангасан агаарын зураг, агаарын зураглалын паспорт, шаардлагад заасан бусад өгөгдөл, баримт бичиг, техникийн даалгавар

Агаарын зураглалын объект: Агаарын зураглалыг нэг техникийн төслийн хүрээнд төлөвлөж гүйцэтгэхэд техникийн тодорхойлолтод заасан хил хязгаар бүхий талбайг хамарсан нутаг дэвсгэр, суурин, хил хязгаар бүхий нутаг дэвсгэрийн багц болон трасс, хил эргийн шугамын дагуу сунасан объект.

Агаарын зургийн аппарат (АЗА): Агаарын хөлөг болон нисгэгчгүй нисэх төхөөрөмжөөс (ННТ)газрын гадаргуугийн зураг авах зориулалттай төхөөрөмж.

АЗА -ын буулгалтын параметрүүд: Хиймэл дагуулын хүлээн авагчийн антены фазын төвийг агаарын зургийн тусгалын төвд буулгах шугаман засвар

Агаарын зураглалын систем: Агаарын зураглалд зориулсан агаарын хөлөг болон ННТ ашиглах техникийн болон программ хангамжийн иж бүрдэл

Агаарын зургийн аппаратын суурь: Агаарын хөлөг болон ННТ-т аппаратыг бэхэлж, хэвтээ хавтгайд хазайлтын өнцгөөр автоматаар эргүүлэх, агаарын зургийн аппаратын чичиргээг бууруулах зориулалттай төхөөрөмж.

Агаарын зургийн тусгалын төв: Объективын урд зангилаа цэгтэй давхацсан тусгалын цацрагуудын огтлолцох цэг.

Битийн гүн: Тоон дүрс зургийн дан өнгөний пикселийн утга илэрхийлдэг битийн тоо

Зөв ортофото: Агаарын зургаас өндрийн тоон загварыг ашиглаж үүсгэсэн ортофото дүрс зургуудыг зүйж нийлүүлсэн байр зүйн тоон дэвсгэр дүрс зураг

Зураг авах өндөр: Агаарын зураглал үйлдэх үед зураглаж буй газрын гадаргуугийн дундаж түвшнээс дээш онгоц болон ННТ хүртэлх эгц босоо зай.

Ортофото: Агаарын зургаас ГТЗ-ыг ашиглаж үүсгэсэн ортофото дүрс зургуудыг зүйж нийлүүлсэн байр зүйн тоон дэвсгэр дүрс зураг

Өндрийн тоон загвар (ӨТЗ): Газрын гадаргуу, түүн дээрх барилга, байгууламж, бусад зүйлсийг илэрхийлэх солбицол, өндөртэй цэгүүдийн олонлог

Пиксел: Гэрэл мэдрэмтгий матрицын хавтгайд гэрэл зургийн аппаратын линзээр үүсгэсэн тоон дүрсийн матрицын элемент

Пикселийн орон зайн хэмжээ: Газрын гадаргуу дээрх пикселийн тусгалын хамгийн их зөвшөөрөгдөх хэмжээ

Пикселийн физик хэмжээ: Агаарын зургийн аппаратын гэрэл мэдрэмтгий матрицын элементийн урт ба өргөнийг метрийн системд илэрхийлсэн хэмжээ

Сканердах хавтгай: Тоон агаарын зураглалын системийн хувьд тусгалын төв ба гэрэл мэдрэмтгий элементүүдийн шугамаар дайран өнгөрөх хавтгай

Тодролт: Тоон дүрс зураг дээрх хоёр хэсгийн өнгөөрөө ялгарах зэрэг

Түүхий агаарын зураг: Нислэг үйлдэх үед агаарын зургийн аппаратаар авсан тоон дүрсийн файл

Хазайлтын өнцгүүд: Лидар эсвэл агаарын зургийн аппаратаар инерцийн хэмжилтийн төхөөрөмжтэй хөдөлгөөнгүй бэхлэгдэж, лидар болон агаарын зургийн аппаратын солбицлын систем инерцийн хэмжилтийн төхөөрөмжийн солбицлын системтэй үүсгэх харьцангуй чиглүүлгийн өнцгүүд

КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Манай компани нь 2018 оноос геодезийн үйлдвэрлэл үйлчилгээ, зураг төсөл, сургалт гадаад худалдааны чиглэлээр байгуулагдсан бөгөөд одоог хүртэл тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж байна.

Бид Хятадын геодези, маркшейдерийн хэмжилтийн багаж тоног төхөөрөмж, дрон лидар, технологийн CHCNAV, RUIDE, DJI, Швейцарын GEOMAX, Америкийн Faro/Geoslam лазер сканер, лидарийн технологийн үйлдвэрүүдийн Монгол дахь албан ёсны төлөөлөгч юм. Оросын Agisfot Metashape, Америкийн Blue Marble Geographics үйлдвэрийн Global mapper, Geocalc программ хангамжуудыг албан ёсны эрхтэй нийлүүлж заавар зөвлөгөө сургалт өгдөг.
Бидний эрхэм зорилго бол инженерийн бүтээн байгуулалт, судалгаа шинжилгээ, хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулж шинэлэг бүхнийг эрэлхийлж , бизнесийн ёс зүйг эрхэмлэн захиалагч, харилцагчдаа хүндэтгэж чанартай үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх явдал юм.

ХОЛБОО БАРИХ:

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26-р хороо,
Санрайз центр 9 давхар 904 тоот
Утас: 7719-7755
И-мэйл хаяг: 5DWORLD@5dworld.mn geodesy@5dworld.mn
Вэб сайт: www.5DWORLD.mn

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- Ажил гүйцэтгэсэн үндэслэл, гэрээ

"Нийслэлийн замын хөгжлийн газар"-ын захиалгаар Тав Ди Ворлд ХХК нь Туулын хурдны замын 32 орчим км авто зам, олон түвшний уулзварууд үүн дотор Дүнжингаравын авто зам, ТЭЦ-3 -ийн авто замуудыг холбох 2.4 км орчим авто замын шинэчлэлтийн зураг төсөл боловсруулах ажлын 1:1000 масштабтай байр зүйн зураг, тайланг боловсруулах, ортофото зураг гаргах ажлыг хийж гүйцэтгэхээр № АГГ-1-122/24 тоот дугаар бүхий гэрээг 2024 оны 10-р сарын 23-нд байгуулсан. Гэрээт ажлыг 2024 оны 10-р сарын 23-аас 2024 оны 12-р сарын 26 хүртэх хугацаанд хийж гүйцэтгэлээ.

- Хийж гүйцэтгэсэн ажлын хэмжээ

Гэрээт ажлын хүрээнд захиалагчийн ажлын даалгавар талбайн хил заагийг үндэслэж дараах ажлыг хийж гүйцэтгэхээр гэрээнд заасан. Үүнд:

Хүснэгт 1

Ажлын төрөл	Хэмжих нэгж	Хэмжээ
Агаарын зураглалын холболтын цэг газарт тэмдэглэж хэмжих	Цэг	200
Агаараас зураг авах	га	1293
Агаарын зураг боловсруулах	га	1293
Байр зүйн зураг үйлдэх	га	1293
Байрлалын сүлжээний статик хэмжилт	цэг	14
Байрлалын сүлжээний хэмжилтийн боловсруулалт	цэг	17
Өндрийн сүлжээний хэмжилт	км	41
Өндрийн сүлжээний хэмжилтийн тэгшитгэн бодолт	км	41
Агаарын шугамын утасны унжилтийн хэмжилт	цэг	38
Ажлын тайлан бичих	ширхэг	2

Бид дээрх ажлыг хийж гүйцэтгэхдээ Монгол улсад мөрдөгдөж буй норм дүрмийг баримталж ажилласан. Үүнд:

- Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан WGS-84 солбицол, UTM тусгагд зураглах.
- Навигацийн хиймэл дагуул (GNSS) -ын технологиор Монгол улсын геодезийн сүлжээ байгуулах дүрэм. БНбД 11-13-22;
- Монгол улсын өндрийн III ба IV ангийн сүлжээ байгуулах дүрэм. БНбД 11-121-19;
- Геодезийн цэг, тэмдэгтийн хайгуул, судалгааны ажлын заавар

  MNS:3951-20 Геодези, зураг зүй. Ерөнхий нэр томьёо, тодорхойлолт

- "1:5000, 1:2000, 1:1000, 1:500-ны масштабтай байр зүйн дэвсгэр зураглалын ажил" /БД 11-06-08/
- "1:5000, 1:2000, 1:1000, 1:500-ны масштабтай зургийн томьёолсон тэмдэг" УГЗЗГ
- Авто зам болон төмөр замын геодезийн ажил. /БД 11-114-14/
- "Геодезийн ажлын аюулгүй ажиллагааны техникийн дүрэм" УГЗЗГ, 1976 он.
- "Нисгэгчгүй нисэх төхөөрөмжөөр агаарын зураглал ба газрын зураг гүйцэтгэх ажил" БД 11-125-21.
- Агаар, сансрын зураглалын ажил БНБД 11-14-23
- MNS:6925-11:2021 Газар зүйн мэдээлэл. Орто-зураглалын орон зайн өгөгдлийн үзүүлэлт

2. БАГИЙН ГИШҮҮД БОЛОН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

➢ Багийн гишүүд

Агаарын зураглалын ажлыг захирал Л.Бат-Эрдэнээр ахлуулсан 6 хүний бүрэлдэхүүнтэй баг хийж гүйцэтгэсэн. Холболт, шалгалтын цэгийг 2-3 хүний бүрэлдэхүүнтэй, нэг автомашин бүхий баг, агаарын зураглалын ажлыг 2 инженер, техникийн ажилчдын бүрэлдэхүүнтэйгээр 1 автомашинтай тус тус хийж гүйцэтгэсэн. Суурин боловсруулалтын ажлыг 5 хүртэлх инженер, техникийн ажилчдын бүрэлдэхүүнтэйгээр хийсэн.

Хүснэгт 2

Д/Д	Нэрс	Албан тушаал	Мэргэжил	Ажилд оролцсон байдал
1	Л. Бат-Эрдэнэ	Захирал	Геодезийн инженер /Геодезийн мэргэшсэн инженер/	Хяналт шалгалт, удирдан зохион байгуулах, агаарын зураглал, хэмжилт боловсруулалт
2	Х. Пүрэвсүрэн	Гүйцэтгэх захирал	Газар зохион байгуулалтын инженер	Хяналт шалгалт, удирдан зохион байгуулах
3	Д. Батсүх	Геодезийн инженер	Геодезийн инженер	Агаарын зураглал, хээрийн хэмжилт, боловсруулалт
4	Г. Батмөнх	Геодезийн инженер	Геодезийн инженер	Агаарын зураглалын ажлын суурин боловсруулалт
5	Э.Далайгүн	Инженер	Газар зохион байгуулалтын инженер	Холболт, шалгалтын цэгийн хэмжилт боловсруулалт
6	Т. Нямсүрэн	Техникч	Газрын тосны инженер	Холболт, шалгалтын цэгийн хэмжилт боловсруулалт

- **Тоног төхөөрөмж**

Дээрх ажилд CHCNAV үйлдвэрийн RTK, PPK хосолсон P330pro VTOL дрон болон CHCNAV V200 загварын дрон, DJI үйлдвэрийн Phantom 4 pro v2 дронуудаар хийж гүйцэтгэлээ. Холболт шалгалтын цэгийг олон долгионы GNSS төхөөрөмж болох CHCNAV үйлдвэрийн i50 -4 ширхэг, i83-1 багажийн тусламжтай хэмжилтийн RTK горимоор хийж гүйцэтгэлээ.

Хүснэгт 3

Багаж тоног төхөөрөмжийн жагсаалт				
Д/Д	**Багажийн нэр**	**Төрөл**	**Сериал дугаар**	**Тайлбар**
1	CHCNAV V200	Дрон	2003040123	RTK Дрон
2	CHCNAV i50 GNSS	RTK GNSS	3325748	Дроны суурин GPS
3	CHCNAV P330	Дрон	2003040123	RTK Дрон
4	CHCNAV i50 GNSS	RTK GNSS	3325748	Дроны суурин GPS
5	CHCNAV i50 GNSS	RTK GNSS	3260275	GNSS-н хүлээн авагч
6	CHCNAV i50 GNSS	RTK GNSS	3250517	GNSS-н хүлээн авагч
7	CHCNAV i83 GNSS	RTK GNSS	3449130	GNSS-н хүлээн авагч
8	RUIDE DSZ2	нивилер	019086	автомат нивилер
9	RUIDE TAL4	нивелир	002989	автомат нивелир

Багаж тоног төхөөрөмжийн баталгаажуулалтын гэрчилгээг хавсралт №3 хавсаргав

CHCNAV V200 дроны техникийн товч үзүүлэлт



Хэмжилтийн горим	RTK/PPK
Нисэх хугацаа:	75 минут хүртэл
Удирдах зай:	17 км / 7000м өндөр
Дээд хурд:	75 км/ц
Салхины тэсвэр:	15 м/с
Ажиллах температур:	-20 - +50
Саад мэдрэгч:	Урд талдаа
Нислэгийн горим:	Автомат/ Гар удирдлага (Маршрутын дагуу нислэг үйлдэж
	автоматаар зураг дарж , бичлэг хийнэ) / A I Spot Check
Байршил тогтоох систем:	BDS B1/B2
	GPS L1/L2
	GLONASS L1/L2
	GALILEO E1/E5b
	QZSS L1/L2

CHCNAV i50 техникийн үзүүлэлт:

Хиймэл дагуулаас хүлээн авах суваг	624
Байршил өндөр тодорхойлох нарийвчлал:	
Статик горим:	Байршил: 2.5mm+0.5ppm
	Өндөр: 5mm+0.5ppm
RTK горим:	Байршил: 8mm+1ppm
	Өндөр: 15mm+1ppm
Ажиллах температур:	-40°C ~ +65°C

CHCNAV V200 дронд зориулсан HC-15 камерын үзүүлэлт:

Пикселийн хэмжээ	42 Мегапиксел
Жин	350 грамм
Санах ойн багтаамж	256ГБ
Фокусын урт	35 мм
Ажиллах температур	-10°C ~ +40°C

3. ФИЗИК ГАЗАРЗҮЙ

➢ Газарзүйн онцлог

Монгол улсын нийслэл Улаанбаатар хот нь далайн түвшнээс дээш 1350 гаруй метрийн өндөрт, 1992 оны шинэ нутаг дэвсгэрийн хуваариар үндсэн 6, дагуул 3, нийт 9 дүүрэгтэй бөгөөд 2024 оны байдлаар 1,7 сая орчим хүн амтай, нутаг дэвсгэрийн хэмжээ 4,704.4 км2. Улаанбаатар хотын өмнүүр орших Богд хан уул нь зүүнээс баруун тийш чиглэсэн 40 орчим километр үргэлжилсэн нуруу,төв хэсэгтээ өндөр уул болон дундаж өндөртэй уулын хэв шинжит уулс, мөн 2268м өндөрт орших Цэцээ гүн, 2256м орчим өндөртэй Түшээ гүн, Баруун, Зүүн Ширээ зэрэг оргилуудтай. Зураглал үйлдэх талбай нь голын голдиролтой ойр гол дагуух бургасан ой модтой хэсгийг их дайрсан байсан.

- **Уур амьсгал**

Улаанбаатар хот нь дэлхийн хамгийн цэлмэг, хөх тэнгэртэй хотуудын нэг бөгөөд жилдээ 250 орчим хоног цэлмэг байдаг. Улаанбаатар хот нь салхи багатай газрын тоонд орох бөгөөд жилдээ салхигүй өдөр 100 орчим байна. Салхины дундаж хурд 4-6м/с бөгөөд голдуу баруун хойд зүгээс салхилна. Салхины хамгийн их хурд 40 м/с хүрч байжээ. Авто замын үндсэн чиглэлийн дагуу авто машины хурднаас хамаарсан 2 чиглэлтэй бичил салхи үүсэн шороон шуурга байнга шуурч, тоос шороо зөөгддөг. Агаар хэт хуурайшиж хатуу хольц ихсэж тоос шороо алсад агаарын урсгалаар дамжин зөөгддөг. Зураглалын хугацаанд цаг агаар зарим өдөр цастай ажил гүйцэтгэх боломжгүй байсан. Агаарын температурын хувьд -8°-аас -14° хооронд хэлбэлзэж зураглалын талбайд хамаарч байсан голын голдирол болон усан сан болж тогтоол үүссэн хэсгүүд нь хангалттай зузаан мөсөн бүрхүүл тогтоогүй зарим хэсгүүдэд гол мөсгүй ил урсаж байсан. Ажил гүйцэтгэх хугацаанд хүчтэй салхи салхилаагүй салхины хурд 2-4м/с байсан.

- **Зам харилцаа**

Улаанбаатар хотод хөдөө орон нутгаас шилжин ирэгсэд нэмэгдсээр байгаа бөгөөд энэхүү хэт их төвлөрлөөс үүдэж хот төлөвлөлт, зам харилцаа, бүтээн байгуулалтад сөргөөр нөлөөлж байна. Энэ их төвлөрлийг сааруулахын тулд хот төлөвлөлтийг шинээр хийх шаардлага тулгараад байна. Улаанбаатар хотын хэт их шавсан барилга байгууламж, гудамж талбайд шинээр зураглалын ажил хийхэд ихээхэн хүндрэл учруулж байгаа бөгөөд үүнийг шийдэх гарц гаргалгаа нь нисгэгчгүй нисэх төхөөрөмж (ННТ)-ийг ашиглах явдал юм. ННТ буюу дрон нь өндөр барилга байгууламжууд болон хэмжилт хийх боломжгүй газрууд дээр агаарын зураглалыг богино хугацаанд хийх чадвартай юм. Өндөр хөгжилтэй улс орнууд хот төлөвлөлт, авто зам, бүтээн байгуулалтын ажилд өргөнөөр ашиглаж байна.

4. Талбайн хэмжилтийн ажил

➢ Хуучин цэгийн судалгаа

Уг төслийн агаарын зураглалын болон GPS-н хэмжилтийн ажилд ГЗБГЗЕГ-н байнгын ажиллагаатай станц UB01-ийг ашиглаж хэмжилт хийсэн. Энэхүү байнгын ажиллагаатай станц нь монгол улсад мөрдөгдөж байгаа заавар, стандарт болон олон улсын стандартад нийцүүлэн баталсан заавар, аргачлалын дагуу суурилуулагдсан, байрлал тодорхойлох Хиймэл Дагуулын Навигацийн систем (GNSS)-д суурилсан АНУ-ын GPS L1, L2 болон ОХУ-ын GLONASS L1, L2 долгионуудыг хүлээн авах антены солбицлолыг олон улсын байнгын ажиллагаатай станцтай харьцангуйгаар ITRF системд өндөр нарийвчлалтайгаар тодорхойлсон, 24 цагийн турш тасралтгүй ажиллагаатай GNSS-н багажийн иж бүрдэл /цаашид CORS гэх/ юм. CORS нь өөрийн байрлалыг статик горимд тасралтгүй хэмжиж байдаг ба өндөр давтамжийн радио долгионоор (UHF modem), өргөн зурвасын богино долгионоор (Bluetooth modem) мэдээлэл дамжуулах технологи, утасгүй интернэтийн сүлжээгээр мэдээлэл дамжуулах (CDMA, GSM modem) технологиор өөрийн байрлалын бодит агшны засвар (RTK) -ыг дамжуулж байдаг. GPS, GLONASS, COMPASS, GALILEO, BAIDU зэрэг хиймэл дагуулуудын байрлал тодорхойлох системүүд нь иргэний хэрэгцээнд нэвтэрч, тэдгээрийн нэгдэл болох дэлхий нийтийн хиймэл дагуулын байрлал тодорхойлох систем буюу GNSS /Global navigation satellite system/-ийг байгуулж, бусад улсуудыг нэгтгэсээр байна. Үүнийг дагаад дэлхийн улс орнууд GNSS-ийн сүлжээг байгуулах, уламжлалт аргаар байгуулсан байрлал, өндрийн сүлжээг нэгтгэх замаар дэлхий нийт, бүс нутгийн хэмжээнд интеграцид орох боллоо. Мөн монгол улсад авто зам, барилга, газрын харилцаа, харилцаа холбоо, хот байгуулалт, уул уурхай зэрэг дэд бүтцийн салбарын хөрөнгө оруулалт сайжирч, тодорхой хууль эрх зүйн орчнууд бүрдсэнээр хот суурин газрыг шинээр болон дахин төлөвлөх, орд газруудыг ашиглах, тэдгээрийг холбосон дэд бүтцийн сүлжээг байгуулах ажлуудын хүрээнд төрийн захиалгат, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгөөр хийгдэх том масштабын байр зүйн дэвсгэр зураг, гүйцэтгэлийн зураг, геодезийн төрөл бүрийн хэмжилтийн ажлууд ихсэж нарийвчлалын шаардлага өндөрсөж байна.

Ашигласан байгын ажиллагаатай корс станцуудын координат, өндөр

Хүснэгт 4

№	Цэгийн дугаар	Тэгш өнцгийн солбицол		Газарзүйн солбицол		Өндержилт
		N	E	B	L	
1	UB-01	5309321.098	642601.4136	47-55-16.82964	106-54-31.67325	1314.2160
2	tuv1	5285774.712	646415.8230	47-42-31.49011	106-57-06.73715	1526.1353
3	ub04	5293407.735	669067.4581	47-46-18.62853	107-15-23.68986	1459.9506

Газар зохион байгуулалт, Геодези, Зурагзүйн ерөнхий газрын Геопортал (https://nsdi.gov.mn/) сайт дээрээс өөрсдийн статик хэмжилт хийсэн үед харгалзах ub01, ub04, tuw01 корс станцуудын статик хэмжилтийн өгөгдлийг татан авч хэрэглэсэн.

Зураг 4.1 Байгын ажиллагаатай суурин станц

Мөн өдрийн сүлжээний хэмжилт хийхийн тулд трассын ойролцоох II-р ангийн сүлжээний цэгүүдийн судалгааг хийж ГБЗЗМэдээлэлийн сангаас цэг тэмдэгтийн мэдээллүүдийг худалдан авч газар дээр судалгаа хийхэд замын трассын төгсгөлөөс 2.5 км байрлах 1747 дугаартай цэгээс бусад нь туул гол дээгүүр тавигдсан гүүрэн байгууламж дээр байрласан байсан нь гүүрийн байгууламжийн шинэчлэл өргөтгөлийн ажилтай холбоотой устсан тул ахин цэгийн судалгаа хийж трассын эхлэлээс хонхор чигт 6.5км-т байрлах Хөлдүү нэртэй цэгийн мэдээллийг мөн худалдан авч ашигласан. Эдгээр цэгийн хувийн хэргийг Хавсралт №8-т хавсаргав.

Зураг 4.2 Нивелирдлэгийн сүлжээнд ашигласан Рп-1747, Хөлдүү

ГБЗЗМэдээлэлийн сангаас худалдан авсан цэг тэмдэгтийн мэдээлэл

"Тав ди ворлд" ХХК

(ААН-ын нэр)

Геодезийн цэгийн солбицол, өндрийн утга

(мэдээлэлийн утга)

2024-10-22

Д/д	Цэгийн дугаар	Анги зэрэг	Тэгш өнцөгтийн солбицол		Геодезийн солбицол		Өндөр, м	Хамаарах шугам
			X	У	B	L		
1	guur	2	5306663.8	654313.2	47° 53' 41.05"	107° 03' 52.25"	1321.1947	19-р шугам
2	4	2	5305558.1	639280.6	47°53'17.64"	106°51'47.36"	1283.619	3-р шугам
3	223	2	5303717.6	633423.4	47° 52' 22.53"	106° 47' 03.40"	1267.6609	3-р шугам
4	1747	2	5306654.6	622859	47° 54' 05.21"	106° 38' 38.03"	1313.2760	1-р шугам
5	185	2	5308783.3	643500.2	47° 54' 58.70"	106° 55' 14.31"	1295.161	17-р шугам

ГБЗЗМэдээллийн сангийн мэргэжилтэн /С.Нарангэрэл/

Геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн сан

Д/д	Аймгийн нэр	Сумын нэр	Цэгийн дугаар	N_UTM	E_UTM	Өргөрөг	Уртраг	Өндөр
1	Улаанбаатар	Баянзүрх	Хөлдүү	5303470.9	658375.5	47° 51' 54.14"	107° 07' 03.56"	1377.5097

ГБЗЗМэдээллийн сангийн мэргэжилтэн /С.Нарангэрэл/

Геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн сан

- **Статик хэмжилтийн ажил**

Цэгийн байрлал тодорхойлох статик хэмжилтийн ажлыг 5 хүний бүрэлдэхүүнтэй 5 баг болж 5 ширхэг GPS-н хүлээн авагч ашиглан гүйцэтгэсэн. RP-1 болон RP-6 цэгүүд дээр хэмжилт эхлэхээс дуусах хүртэл өглөөний 9 цагаас оройн 9 цаг хүртэл 12 цагийн турш хэмжилт хийсэн. Бусад цэгүүд дээр 1-3 цагийн статик хэмжилтийг хийсэн. Байрлалын сүлжээний тулгуур цэгээр Улаанбаатар хотын КОРС станц UB01, Налайх дүүргийн КОРС станц UB04, Төв аймгийн КОРС станц tuw01 гэсэн байнгын ажиллагаатай станцуудын өгөгдлийг Газар зохион байгуулалт геодези зурагзүйн ерөнхий газрын https://monpos.gazar.gov.mn/ сайтаас статик хэмжилтийн өгөгдлийг авч ашигласан. Статик хэмжилтийн бодолтыг албан ёсны лицензтэй CHC Geomatic office 2.0 программаар бодолт хийсэн.

Бодолтоор гарсан үр дүнг хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт №4

Нэр	North	East	Height
tuv1	**5285774.712**	**646415.823**	**1526.135**
ub01	**5309321.098**	**642601.414**	**1314.216**
ub04	**5293407.735**	**669067.458**	**1459.951**
Rp	5306482.700	651129.410	1310.577
Rp2	5306186.680	648843.039	1303.265
Rp3	5305341.885	645136.109	1296.229
rp4	5305847.320	641014.675	1285.140
ГЦТ-007	5305584.349	639229.076	1281.249
ГЦТ-5760	5305479.184	637713.039	1284.601
Rp-6	5305987.842	624770.664	1278.531
Рп-1747	5306653.429	622860.916	1313.352
ГЦТ-5756	5304990.740	635603.994	1270.794
ГЦТ-5764	5304463.948	631126.985	1258.892
ГЦТ-5772	5304199.537	628892.985	1252.202
ГЦТ-8494	5304026.189	633343.671	1264.637
Rp-5	5304355.961	625928.365	1270.077
Rp-1	5306777.305	653168.779	1317.354

Байрлалын сүлжээний хэмжилтийн бодолтын тайланг №4 хавсаргав.



Зураг 4.3 Хэмжилтийн өмнөх бэлтгэл ажил, тест хэмжилт

Зураг 4.4 Статик хэмжилт хийж буй байдал

➢ Өндрийн сүлжээний хэмжилтийн ажил

Нивелирдлэгийн сүлжээний хэмжилтийг өндрийн сүлжээний I, II ангийн сүлжээнд үндэслэн байгуулна гэж заасны дагуу трассын төгсгөлөөс 2.5 км-т байрлах II ангийн сүлжээний цэг Рп-1747 дугаартай цэгээс эхэлж трассын тэнхлэгийн дагуу шинээр суулгасан болон хуучин байсан GPS-н сүлжээний цэгүүдээр дайран нивелирдлэг хийж трассын эхлэлээс 6.5 км орших II ангийн сүлжээний Хөлдүү цэг рүү холбож нивелирдсэн. Нийт 41 км уртад нивелирдлэгийн ажил гүйцэтгэсэн. 1 авто машинтай 5 хүний бүрэлдэхүүнтэй баг 6 хоногийн турш нивелирдлэгийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Нивелирдлэг хийх хугацаанд салхигүй тогтуун байсан. Нивелирдлэгийг RUIDE брэндийн 2 ширхэг автомат нивелир ашиглаж багажийн 2 түвшингээр 2 гараар хэмжиж тооллын зөрүүг 2мм-с их гарсан тохиолдолд багажийн түвшинг өөрчлөн зоож ахин хэмжиж байсан. Багажаас рейк хүртэлх зайг 75 метрээс ихгүй байхаар, 2 талын рейкний зайны зөрүү 5 метрээс ихгүй байхаар хэмжилтийг гүйцэтгэсэн. Дундын зогсолтын цэгүүдэд рейкийг суурилуулах зориулалттай бөмбөгөр толгойтой төмөр башмак ашиглаж хэмжилтийг хийсэн. Өндрийн сүлжээний хэмжилтийн схемийг Хавсралт №5-д хавсаргав.

Зураг 4.5 *Нивелирдлэгийн сүлжээнд ашигласан рейк болон башмак*

Зураг 4.6 Нивелирдлэг хийж буй үеийн зураг

Зураг 4.7 Нивелирдлэг хийж буй үеийн зураг

Өндрийн сүлжээний тэгшитгэн бодолтын хүснэгт

хүснэгт-5

№	Цэгийн нэр	Хэмжилт №1 м	Хэмжилт №2 м	Дундаж өндөр м	Өндөр-жилт м	Зай км	Засвар м	Засварласан өндержилт м	Засварласан өндөр м
1	Rp-1747	1313.276	1313.276	1313.276					1313.276
					34.873	2.6	-0.003	34.876	
2	РП -6	1278.398	1278.408	1278.403					1278.400
					8.465	2	-0.003	8.468	
3	РП -5	1269.935	1269.940	1269.938					1269.931
					17.908	3.4	-0.005	17.912	
4	ГЦТ-5772	1252.028	1252.032	1252.030					1252.019
					-6.706	2.3	-0.003	-6.703	
5	ГЦТ-5764	1258.735	1258.737	1258.736					1258.722
					-5.762	2.4	-0.003	-5.758	
6	ГЦТ-8494	1264.499	1264.496	1264.498					1264.481
					-2.335	0.6	-0.001	-2.335	
7	ГЦТ-6984	1266.836	1266.830	1266.833					1266.815
					-3.849	1.9	-0.003	-3.846	
8	ГЦТ-5756	1270.686	1270.678	1270.682					1270.662
					-13.810	2.2	-0.003	-13.807	
9	ГЦТ-5760	1284.494	1284.490	1284.492					1284.469
					3.342	1.5	-0.002	3.344	
10	РП-007	1281.153	1281.147	1281.150					1281.125
					-3.889	1.8	-0.002	-3.886	
11	РП-4	1285.041	1285.036	1285.039					1285.011
					-11.097	4.5	-0.006	-11.091	
12	РП -3	1296.139	1296.133	1296.136					1296.102
					-7.044	4.6	-0.006	-7.038	
13	РП -2	1303.184	1303.177	1303.181					1303.141
					-7.322	2.4	-0.003	-7.318	

14	РП	1310.506	1310.498	1310.502					1310.459
					-6.893	2.2	-0.003	-6.890	
15	РП-1	1317.400	1317.390	1317.395					1317.349
					-60.170	6.6	-0.009	-60.161	
16	Хөлдүү	1377.568	1377.561	1377.565					1377.510
Нийт					-64.289	41	-0.055		

$f_{зөв}=\pm10*\sqrt{L_{км}}$	64	мм
$\sum h$ хэм	-64.289	м
$\sum h$ онол	-64.234	м
F_h	-0.055	м
L зай	41	км

Дээрх хэмжилтийн 41км зайд зөвшөөрөгдөх алдаа 64мм. Харин бидний хэмжилтээр гарсан алдаа нь 55мм болж байгаа тул дээрх нивелирдлэгийн ажил нь III ангийн нивелирдлэгийн шаардлагыг хангасан болно.

Өндрийн сүлжээний хэмжилтийн журналыг хавсралт №6 хавсаргав.

Цэг тэмдэгтүүдийн байрлал өндөр

Хүснэгт 6

№	Цэгийн нэр	Солбицол				Өндөр
		Тэгш өнцгийн UTM-48N		Газарзүйн солбицол		
		N	E	B	L	
1	**Хөлдүү**	5303470.900	658375.500	107-07-03.56000	47-51-54.14000	1377.510
2	Rp	5306482.700	651129.410	107-01-18.78188	47-53-37.91729	1310.459
3	Rp2	5306186.680	648843.039	106-59-28.36617	47-53-30.25867	1303.141
4	Rp3	5305341.885	645136.109	106-56-28.92323	47-53-05.96765	1296.102
5	гр4	5305847.320	641014.675	106-53-11.16582	47-53-25.63722	1285.011
6	ГЦТ-007	5305584.349	639229.076	106-51-44.91458	47-53-18.52747	1281.125
7	ГЦТ-5760	5305479.184	637713.039	106-50-31.82460	47-53-16.30039	1284.469
8	RP-6	5305987.842	624770.664	106-40-09.37788	47-53-42.29691	1278.400
9	**РП-1747**	5306653.429	622860.916	106-38-38.11977	47-54-05.17335	1313.276
10	ГЦТ-5756	5304990.740	635603.994	106-48-49.76046	47-53-02.10399	1270.662
11	ГЦТ-5764	5304463.948	631126.985	106-45-13.70873	47-52-48.39754	1258.722
12	ГЦТ-5772	5304199.537	628892.985	106-43-25.90929	47-52-41.46570	1252.019
13	ГЦТ-8494	5304026.189	633343.671	106-46-59.90166	47-52-32.58147	1264.481
14	RP-5	5304355.961	625928.365	106-41-03.39821	47-52-48.64815	1269.931
15	RP1	5306777.305	653168.779	107-02-57.31502	47-53-45.71289	1317.349

Цэг тэмдэгтийн хувийн хэргийг хавсралт №8-д хавсаргав.

- **Зураглалын хэмжилтийн ажил**

Зураглалын ажлыг захиалагчаас өгсөн талбайд агаарын зураглал болон GNSS-ийн технологийг хослуулан хийж гүйцэтгэсэн. Холболтын цэгүүд болон зарим хэсгүүдийг RTK (real time kinematik) буюу хөдөлгөөнт хугацааны хэмжилтийн аргаар CHCNAV i50 маркийн GPS-ийг ашиглан хэмжиж тодорхойлсон.Захиалагчаас өгөгдсөн зураглалын талбайд агаарын зураглал хийхэд зориулж нийт 200 холболт болон шалгалтын цэгийг тэмдэглэж, хэмжиж тодорхойлсон байна."Агаар, сансрын зураглалын ажил "(БНБД 11-14-23-ын 3.4.8) – ийн 5.АГААР, САНСРЫН ЗУРАГЛАЛЫН ГЕОДЕЗИЙН ҮНДЭСЛЭЛ -ийн 5.1.-д "Геодезийн сүлжээний цэг, газрын холболт, хяналтын цэг байгуулах" норм нормативыг үндэслэн 5.1.5.1. 1:1000 болон түүнээс том масштабтай дэвсгэр зурагт асфальт, бетон эсхүл плитаны бүрхүүлийн булан, газар доорх байгууламжийн таг, явган замын тод харагдах булан тэмдэг тэмдэглэгээг хийж гүйцэтгэнэ гэсэн тус тус заалтыг үндэслэн зам талбайтай хэсгүүдэд улаан болон цагаан өнгийн шүршдэг будгаар тэмдэглэж өгсөн.

Зураглалд Монгол улсад баримталж буй "UTM 48N" тэгш өнцгийн солбицлын системийг тулгуур болгон ашигласан ба тусгагийн өгөгдлүүдийг доор үзүүлэв.

Хүснэгт 7

Суурь эллипсиод	WGS-84
Тусгаг	UTM48N
Бүсийн дугаар	48
Төвийн меридианы утга	105°
У тэнхлэгийн эхлэлийн утга	500000 м
Х тэнхлэгийн эхлэлийн утга	0
Төвийн меридианы дагуух масштабын утга	0.9996



Зураг 4.8 *UTM зоны хуваалга зураг*

Агаарын зургийг геодезийн солбицол, өндрийн системд холбохын тулд газар дээрх солбицол, өндөртэй тодорхой тооны цэгүүдийг агаарын зурагт таниулах шаардлагатай байдаг. Тэмдэглээсний хэмжээснүүд нь агаараас авсан зураг авах GSD-ийн хэмжээнээс хамаардаг.Тэмдэглээсний өнгийг сонгохдоо тухайн зураглах талбайн гадаргаас ялгарах өнгийг сонгох ёстой байдаг. Агаарын зургийн холболтын болон шалгалтын таних цэгүүдийн хоорондох зай төлөвлөсөн маршрутад холболтын цэг хоорондын зай 300 метрээс ихгүй байхаар тооцов. Таних цэгүүдэд тэмдэглээс тавихдаа цагаан болон улаан өнгийн шүршдэг будгаар 15-20 см-ийн хэмжээтэй дугуй болон хэрээс тэмдэглэгээг хийж өгсөн. Байгалийн хучилтгүй газруудад нэг удаагийн цаасан тавгийг 120мм-н хадаасаар газарт хадаж тэмдэглээд тавагны төвд 5см орчим улаанаар цэглэж тэмдэглэсэн. Агаар,сансрын зураглалын ажил гүйцэтгэх барилгын норматив баримт бичгийн 4.3.3 - Газрын холболтын цэгүүдийг хамгийн багадаа сансрын зургийн хамрах талбайн булан ба төв хэсэгт төлөвлөө гэсэн заалтыг баримталж ажилласан. Талбайн бус шугаман нислэг үйлдэж байгаа үед холболтын цэг хоорондын зайг 250-350 метр зайтай байхаар төлөвлөж тэмдэглэсэн. Холболтын цэгийн солбицол өндрийг хэмжиж тодорхойлохдоо "Газар Зохион Байгуулалт, Геодези Зураг Зүйн газрын Корс станц ub01-тэй холбогдож WGS84 - UTM-48N солбицлын тогтолцоонд, Улаанбаатар хотын 2018 оны геоидийн загвар mongeoid-ub2018.grd-г ашиглаж хэмжсэн.

Холболтын цэгүүдийг RTK (real time kinematik) буюу хөдөлгөөнт хугацааны хэмжилтийн аргаар CHCNAV i50 маркийн GPS-ийн хүлээн авагч ашиглан хэмжиж тодорхойлсон. Энэ нь дэлхий дахинд GPS-н технологи иргэний хэрэглээнд нэвтэрснээр геодезийн үйлдвэрлэлд гарсан маш чухал дэвшил бөгөөд өндөр нарийвчлалтай тодорхойлогдсон цэг дээрх GPS-ийн суурин станцаас өндөр давтамжийн радио долгион(UHF modem), өргөн зурвасын богино долгионоор (Bluetooth modem) мэдээлэл дамжуулах технологи, утасгүй интернэтийн сүлжээгээр мэдээлэл дамжуулах (CDMA, GSM modem) аудио модем зэрэг өгөгдөл дамжуулах технологийн тусламжтайгаар орчны барилгажилт, долгион сарниулагч хүчин зүйлсээс хамааран 2-25км зайд өөрийн байрлалын мэдээллийг түгээж байх ба 2 долгионы GPS-н хүлээн авагчийн тусламжтайгаар өөрийн байрлалыг маш бага алдаатайгаар тодорхойдог GPS-н хэмжилтийн нэг арга юм. Энэ арга нь нарийвчлалын хувьд байрлалыг 1-2см алдаатай байх тодорхойлдог. Захиалагчаас өгөгдсөн зураглалын талбайд агаарын зураглал хийхэд зориулж нийт 200 орчим холболтын болон хяналтын цэг тэмдэглэн тодорхойлсон.



Зураг 4.8 *Холболтын болон хяналтын цэгийн хэлбэр*

Холболтын цэгийг ихэвчлэн дугуй болон хэрээс “X” хэлбэртэйгээр газар дээр тэмдэглэж өгсөн. Нислэгийн GSD=2.0 байсан учир дээрх зурагт заасан хэмжээнээс багагүйгээр тэмдэглэсэн.

Зураг 4.9 *Газар дээрх хяналтын цэгийн хэмжилт хийж буй байдал*

Холболтын цэгүүдийг GPS-н хазгай хэмжилтийн горимыг асааж, таягийн тэгш усны цэврүүг голлуулан барьж 30 секундийн хэмжилтээр RTK хэмжилтийн горимоор "control point "төрлөөр хэмжиж тодорхойлсон.

Зураг 4.10 *Газар дээр холболтын цэгүүдийг тэмдэглэсэн байдал*



Зураг 4.11 *Холболтын цэгүүд Metashape боловсруулалтын программ дээр харагдаж буй байдал*

- **Нислэг төлөвлөлт**

Байр зүйн зургийн масштаб буюу зургийн нарийвчлал, байр зүйн зураг хийгдэх газар нутгийн байдал, цаг уурын онцлог, агаарын зураг авах камерын хүчин чадал, удирдлагын болон боловсруулалтын программ хангамж, компьютерын техник, хангамжийн хүчин чадал зэрэг олон хүчин зүйлсийг үндэслэн нислэгийн төлөвлөлтийн элементүүд болох нислэгийн өндөр, дагуу болон хөндлөн давхцал, нэг блокт хамрагдах талбай, холболтын болон хяналтын цэгүүдийн тоо хэмжээ, байршил зэргийг тооцоолон гаргадаг. Бид дээрх хүчин зүйлүүдийг тооцон үзэж агаарын зургийн дагуу давхцалыг 80%, хөндлөн давхцалыг 75% байхаар тус тус төлөвлөсөн. Дронуудын нислэгийн өндрийг Хүснэгт 7- д үзүүлэв.

Хүснэгт 7

ННТ-ийн төрөл	GSD	Камерын төрөл	Камерын пиксел	Нислэгийн өндөр
P330	2.0см	Sony a7R4	61мегапиксел	215 метр
V200	2.0 см	HC-15	45 мегапиксел	155 метр

Хоёр талбайн зах хэсэг буюу нийлж байгаа хэсэгт давхцалуудыг 50-100метр байхаар төлөвлөн нисгэсэн. Агаарын зураглал үйлдэх нислэгийн цагийг төлөвлөхдөө аль болох нар голлосон, сүүдэр бага үүсэх хугацааг сонгож өглөөний 11 цагаас өдрийн 16 цагийн хооронд нислэг үйлдэхийг эрмэлзэж байсан.

Агаарын зураглал үйлдэх нислэгийн төлөвлөхдөө цаг агаарын урьдчилсан мэдээг Цаг уур, орчны шинжилгээний газрын http://www.tsag-agaar.gov.mn болон https://www.windy.com веб сайтуудаас авч ашигласан.

Нарны гадарга дээр үүссэн хүчтэй дэлбэрэлтийн улмаас үүссэн плазмын урсгал дэлхийн бөмбөрцөгт хүрэх үзэгдлийг соронзон шуурга гэдэг.

Соронзон шуурга нь хиймэл дагуулын ажиллагаанд доголдол үүсгэж радио холбоог саатуулж, нисгэгчгүй нисэх төхөөрөмж (ННТ) -г удирдлагагүй болгох магадлалтай. Хот суурин газар агаарын зураглал үйлдэж байгаа үед ННТ

удирдлагаа алдаж барилга байгууламж, машин техник болон хүн дээр унах эрсдэлтэй.Энэ эрсдэлээс урьдчилан сэргийлж Magnetology апплэкейшн ашигласан бөгөөд соронзон шуурганы түвшин Кр=5 болон түүнээс дээш байх тохиолдолд ННТ-өөр нислэг үйлдэхээс зайлсхийж байсан.

Зураг 4.12 Magnetology апплэкейшн



Зураг 4.13 Соронзон шуурганы түвшинг диаграммаар харуулсан байдал

Нислэгийн хугацаанд 3 өдөр соронзон шуурганы түвшин Кр5-6 байсан.

- **Агаарын зураглал**

Шинжлэх ухаан, техник технологи эрчимтэй хөгжиж буй өнөө үед дэлхий нийтэд нисэгчгүй нисэх төхөөрөмжийг (ННТ) олон салбарт өргөн хэрэглэх боллоо. ННТ нь олон улсын хэмжээнд уул уурхай, байгаль орчин, цахилгааны шугам сүлжээний мониторинг хийх, 3 хэмжээст загвар үүсгэх болон байр зүйн зураглалын ажилд ашиглагдан нарийвчлал, цаг хугацаа, хүн хүчний зарцуулалт, эдийн засгийн хувьд давуу гэдгээ баталсаар байна. Мөн ННТ-ийн технологи нь хурдацтай хөгжиж саад мэдрэгчтэй, гар удирдлагатай, GNSS сигнал хүлээн авах чадвартай, камер тогтворжуулагчтай, газрын хяналтын цэггүй ч өндөр нарийвчлалтай зураглал хийх боломжтой болж байгаа нь том масштабын байр зүйн зураглалын ажилд ашиглах боломжийг бүрдүүлж байна. ННА зориулалт

ба гүйцэтгэх үүргээс хамааран олон төрөл загвар байдаг ба үүнээс геодезийн салбарт сэнст буюу коптер болон далавчит загварыг ашигладаг. Агаарын зураглалын ажлыг гүйцэтгэхэд бид далавчит загварын CHCNAV VTOL P330 pro RTK болон коптер загварын CHCNAV v200 RTK дронуудыг 45MP болон HC15 камерын хамт ашигласан.RTK PPK дронуудад газар дээрх хяналтын холболтын цэг /GCP/ шаардлагатай байдаг ба RTK болон PPK дрондуудад уг цэгүүдийг байршуулах шаардлагагүй байдаг. Агаарын зураглалд ашигласан манай дрон нь RTK/PPK горим бүхий мэргэжлийн дрон юм.



Зураг 4.14 *Дроны төрлүүд*

Агаарын зураглалыг энгийн дрон болон RTK, PPK гэсэн 3 төрлийн дроноор хийж гүйцэтгэх боломжтой.

Агаарын зураглалын бүдүүвч схем



CHC V200 HHT дээр төлөвлөлт болон нислэг үйлдэхдээ GCS программ хангамжийг ашигласан.

Зураг 4.15 *HHT-ийн нислэгийн болон төлөвлөлтийн программ хангамж Ground Control System / GCS /*

Зураг 4.16 CHCNAV V200 дрон

Зураг 4.17 CHCNAV V200 дроны удирдлага

Зураг 4.18 *CHCNAV V200 дроны бэйс станц*



H - Нислэг хийж буй өндөр

D Удирдлагаас ННТ хүртэлх зай

S – ННТ-ийн хурд

73% - ННТ-ийн батарей

8% -Удирдлага буюу таблетын батарей

Speed: 10м/с

-Төхөөрөмжийн хурд

Photos: 1073 зургийн тоо

Photo Distance:21.2м

-Зураг хоорондын зай

Height: 155м - Нислэгийн өндөр

Areas: 1.055км2 Талбайн хэмжээ

Course distance: 47.7

Замналын зай: 47.7

Camera: Камерын төрөл HC15

GSD:2.0 см

Front Overlap: 80%

Дагуу давхцал: 80%

Side Overlap: 70%

Хөндлөн давхцал: 70%

Speed(m/s)Хурд:10м/с

Course Angle:Замналын чиглэл.

Зураг 4.19 *ННТ-өөр нислэг үйлдэхэд удирдлагын таблетад харагдах байдал*

P330pro HHT-өөр агаарын зураглалыг үйлдэхдээ **Easyfly** программ хангамжийг ашиглан нислэгийн төлөвлөлт хийх болон нислэг үйлдэхэд ашигласан.

Зураг 4.20 ***CHCNAV EasyFly*** *төлөвлөлт болон нислэгийн программ хангамж*

Зураг 4.21 *CHCNAV P330 pro VTOL HHT*

- Камер- A7R4
- GSD-2.0 см
- Дагуу давхцал - 80%
- Хөндлөн давхцал - 75%
- Нислэгийн хугацаа-0:37:3
- Нислэгийн өндөр-215 метр
- Нийт нислэгийн урт-44.46км
- Авах зургийн тоо-0775

Зураг 4.22 *EasyFly программ хангамж дээрх нислэгийн төлөвлөлт*

Зураг 4.23 *CHCNAV P330 HHT-ийн нислэгийн замнал*

Агаарын зураглалыг хийж гүйцэтгэхээс өмнө нисэх төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, цаг агаарын нөхцөл байдал, орчин тойрны үзлэгийг маш сайтар шалгаж, аюул байдлаа бүрэн хангасаны дараа нислэгийг үйлдсэн.Нислэгийг үйлдэхээс өмнө стандарт, журмыг хангасан агаарын зургийн паспортыг хөтөлсөн бөгөөд Хүснэгт 8-т үзүүлэв.

Хүснэгт 8

Агаарын зургийн паспорт №1						
Он сар өдөр	23/10/2024		**ННТ-ийн сериал дугаар, загвар**	V200	**Байрлал**	Улиастай гүүр
Зургийн аппаратын загвар, сериал	HC15		**Нисгэгч, операторын нэр**	Батсүх	**Нислэг эхэлсэн цаг**	12:00
					Нислэг дууссан цаг	12:40
GSD	2		**Талбайн хэмжээ га**	77	**Нислэгийн хязгаар**	
Цаг агаарын байдал	Цаг агаар _____Нартай_____ Салхины хурд_____4м/с___ Салхины чиглэл_____БХ____					
Газар нутгийн байдал	Уулархаг газар____ Хот суурин газар____ Хотын зах газар _+___ Бусад____					
Дагуу давхцал	80		**Хөндлөн давхцал**	75	**Нислэгийн өндөр**	194
Ашигласан батарейны тоо	2		**Нислэгийн хурд**	12 м/сек	**Камерын өнцөг**	0
Багажийн өндөр	**Асаасан цаг**	11:50	**Зургийн тоо**	690	**GCP**	8
1.254	**Унтраасан цаг**	1:00	**Эвэнтийн тоо**	690	**Хяналтын цэг**	2
Тайлбар:						

Нисгэгчгүй нисэх төхөөрөмжөөр агаараас зураг авах ажиллагааг ННТ-үүдийн туршилт, бэлтгэл ажлыг хангаж 10-р сарын 23-ны өдрөөс эхлэн 11-р сарын 14 өдөр хүртэл нийт 21 хоногт нисгэж дуусгасан. Нийт 1293 га талбайг зурагласан. Бүрхэг өдөр нар буусан үед(4:30 минут) нислэг үйлдсэн үед зураг хар өнгөтэй шаардлага хангахгүй гарч байсан тул давтан нислэг хийх шаардлага гарч байсан. Нийт 143 га талбайг давтан нислэг үйлдсэн. Агаарын зургийн паспортыг хавсралт № 7-д хавсаргав.

Нийт 20 удаагийн нислэг үйлдсэнээс V200 дроноор нийт 17 удаагийн нислэг үйлдэж 800 га талбайг зурагласан. V200 дрон нь газрын гадарга дагаж нисдэг.



Зураг 4.4.13 *V200 дрон нислэг үйлдэхэд бэлдсэн байдал*

P330pro дроноор нийт 3 удаагийн нислэг үйлдэж 637 га талбайг зурагласан. Дроныг нисгэх удирдлага нь компьютер байдаг тул автомашины цахилгаан үүсгүүрт хүчдэл өсгөгч залган компьютерыг цэнэглэж ашиглаж байсан.

Зураг 4.4.14 *P330 нислэг үйлдэж байгаа байдал*

Шугаман нислэгийн зураглалын хилийн өргөн 140 метр боловч V200 дроны нислэгийн бодит өргөн 260 метр , P330 дроны нислэгийн бодит өргөн 400-450 метрээр хэмжигдэж байсан.Нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн нислэгийн өргөний жишээ зургийг Зураг 4.4-т үзүүлэв.

Зураг 4.4.15 *P330 дроны нислэгийн өргөн*

Зураг 4.4.15 *V200 дроны нислэгийн өргөн*

Агаарын зураглалын нислэгийн нэгдсэн бүртгэлийг Хүснэгт 9 -т харууллаа.

